



ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Пүүдун: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ” ХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Дүгнэлт

Хураангуй санхүүгийн тайлан нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлого үр дүн, бусад дэлгэрэнгүй орлогын тайлангаас бүрдсэн.

Бидний дүгнэлтээр хавсралт дахь “Ард Санхүүгийн Нэгдэл” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Аудитлагдсан Санхүүгийн Тайлан, түүний нэмэлт тодруулгатай тохирч байна.

Санхүүгийн хураангуй тайлан

Энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС-ын) шаардсан бүх тодруулгыг агуулаагүй болно. Иймд энэхүү санхүүгийн хураангуй тайлан нь Сангийн сайдын баталсан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу илэрхийлэгдсэн аудитлагдсан санхүүгийн тайланг орлохгүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба бидний дүгнэлт

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон тус компанийн санхүүгийн тайланд хязгаарлалтгүй санал дүгнэлт өгсөн. Уг тайланд аудитын гол асуудлын талаарх мэдээллийг тусгасан. Аудитын гол асуудал нь бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн чухал асуудал байдаг.

Хураангуй тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь эрх бүхий байгууллагын баталсан журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, түүндээ үндэслэн хураангуй санхүүгийн тайлангаа үнэн зөв бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Компанийн зүгээс бэлтгэсэн хураангуй санхүүгийн тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байгаа эсэхийг шалгах, АОУС 810 буюу “Хураангуй санхүүгийн тайлангийн талаар тайлагнах гэрээт ажлууд”-аар шаардсан горимуудыг гүйцэтгэж дүгнэлт өгөх явдал юм.



2020 ОНЫ 03 ДУГААР
САРЫН 25-НЫ ӨДӨР

АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК

2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй санхүүгийн байдлын тайлан

Үзүүлэлт	2019.12.31. мянган төгрөг	2018.12.31. мянган төгрөг
<u>ХӨРӨНГӨ</u>		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	43,235.6	2,034.8
Худалдааны болон худалдааны бус авлага	4,902,640.1	3,001,265.8
Бусад олгосон зээл, зээлийн хүүний тооцоо	403,269.0	6,820,414.5
Татвар, шимтгэлийн авлага	6,864.8	14,941.4
Бараа материал	6,231.1	36,364.2
Урьдчилж төлсөн зардал	3,685,467.0	830,472.0
Богино хугацаат хөрөнгө оруулалт	13,989,498.9	146,055.7
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		2,400,000.0
Үндсэн хөрөнгө (цэвэр)	642,006.7	739,940.7
Биет бус хөрөнгө (цэвэр)	127,431.2	246,604.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	54,265,176.2	43,810,718.8
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		2,417,832.1
НИЙТ ХӨРӨНГӨ	78,071,820.6	60,466,644.6
<u>ӨР ТӨЛБӨР</u>		
Худалдааны болон худалдааны бус өр төлбөр	2,333,638.6	131,267.0
Бусад өглөг	12,901.7	12,675.8
Богино хугацаат зээл	1,082,465.3	1,814,620.0
Түрээсийн өрийн богино хугацаанд төлөгдөх хэсэг	41,096.3	
Хүүний өглөг	198,315.5	251,491.3
Татварын өглөг	68,822.0	23,877.4
Урт хугацаат зээл	2,236,039.0	240,370.2
Түрээсийн өр төлбөр	261,389.7	
Бусад урт хугацаат өр төлбөр	12,183,954.7	5,524,671.1
Хойшлогдсон татварын өглөг	3,070,863.0	1,957,039.5
Нийт өр төлбөр	21,489,485.8	9,956,012.3
<u>Өөрийн хөрөнгө</u>		
Энгийн хувьцаа	28,590,335.0	1,879,652.8
Халаасны хувьцаа	(1,414,706.0)	(160,216.4)
Нэмж төлөгдсөн капитал		9,929,060.7
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөц сан	16,124,512.7	14,081,066.0
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	13,799.1	13,799.1
Хуримтлагдсан үр дүн	13,268,394.0	24,767,270.1
Нийт өөрийн хөрөнгө	56,582,334.8	50,510,632.3
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ	78,071,820.6	60,466,644.6

2019 оны 12 дугаар сарын 31-ээрх хураангуй орлого үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

Үзүүлэлт	2019.12.31. мянган төгрөг	2018.12.31. мянган төгрөг
Борлуулалтын орлого	1,569,829.5	3,863,044.9
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		
Нийт ашиг	1,569,829.5	3,863,044.9
Хүүний орлого	304,891.3	351,531.9
Ногдол ашгийн орлого	537,156.7	897,653.7
Бусад орлого	87,252.3	296,165.6
Борлуулалт, маркетингийн зардал	(1,262,376.9)	(322,092.8)
Ерөнхий удирдлагын зардал	(4,441,981.1)	(3,209,382.0)
Хүүний зардал	(1,454,685.7)	(854,143.2)
Бусад зардал	(132,645.1)	(104,602.4)
Гадаад валютын ханшийн зөрүү олз (гарз)	(20,035.5)	54,643.7
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(34,430.2)	
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	163,761.1	
Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз(гарз)	9,059,062.8	(180,267.8)
Татварын өмнөх ашиг (алдагдал)	4,375,799.2	792,551.6
Орлогын албан татварын зардал	(970,978.2)	(124,918.6)
Тайлант жилийн татварын дараах ашиг (алдагдал)	3,404,821.0	667,633.0
<u>Бусад дэлгэрэнгүй орлого:</u>		
Хөрөнгө оруулалтын үнэлгээний нөөцийн цэвэр өсөлт	2,043,446.8	6,730,845.0
Нийт дэлгэрэнгүй орлого	5,448,267.8	7,398,478.0
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	155.17	38.83

"DALAIVAN AUDIT" Co., Ltd

CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL